ЭДИЙН ЗАСГИЙН БОДЛОГО, ӨРСӨЛДӨХ ЧАДВАРЫН СУДАЛГААНЫ ТӨВ
Economic Policy and Competitiveness Research Center

Уул уурхайн лицензийг тойрсон асуудлууд

Илтгэгч: Б.Лакшми
Discovery Mongolia – 2011
Улаанбаатар хот
2011.09.07

Нийт лицензийн тоо /ашиглалт болон хайгуул/



Эх сурвалж: Лиценз ажиглагч №16, Нээлттэй нийгэм форум

Аймгууд дахь лицензийн тоо



Лицензийн талаар ерөнхий мэдээлэл

- Нэг лицензээр авч болох талбай
  - 10 000 – 400 000 га талбай
- Одоогоор лицензз авах 2 арга зам байна
  1. Өөрсдөө урьдчилан судалгаа хийж солбилцлоо тогтоон өргөдлөө өгөх (Анхдагч лицензз)
  2. Сонгон шалгаруулалтанд оролцох

Анхдагч лиценз авах шат дамжлага

ААН нь АМГ-т өргөдөл гаргана.

АМГ өргөдлийг тухайн аймгийн засаг дарга руу явуулна.

Аймгийн засаг дарга хуулийн дагуу 30 хоногийн дотор хариу өгнө.

- Аймгийн засаг дарга 30 хоногийн дотор хариу өгөөгүй тохиолдолд лицензийг шууд олгоно.
- Аймгийн засаг дарга татгалзсан хариу өгөх тохиолдолд үндэслэлээ заавал бичих шаардлагатай. Үндэслэл бичээгүй тохиолдолд лицензийг олгодог.
- Аймгийн засаг дарга нь Иргэдийн төлөөлөгчдийн тэргүүлэгчид болон сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлаас эхлэн зөвшөөрөл авсны үндсэн дээр зөвшөөрсөн хариу өгөх эрхтэй.

Сонгон шалгаруулалтанд ордог лицензүүд

- Буцаагдсан /компаниуд авсан лицензээ зарим тохиолдолд буцааж өгдөг/
- Хураагдсан /жил болгон ашиглалтын төлбөр төлдөг. Энэ төлбөрөө цаг хугацаанд нь төлөөгүй 1 хоног л хоцроосон тохиолдолд лицензнь хураагддаг/

Лиценз авахад бүрдүүлэх бичиг баримтууд

- Байгууллагын гэрчилгээ.
- Авах гэж буй орд газрын солбилцол.
- Байгууллагын геологийн ажилчдын анкет, диплом, иргэний үнэмлэхний хуулбар.
- Хураамж.

Зайлшгүй хийгдэх шаардлагатай ажлууд

Давхар хяналтын систем нэвтрүүлэх

Улсын мэргэжлийн хяналт → Орон нутгийн мэргэжлийн хяналт → Уул уурхайн компани

Одоогийн нөхцөл байдал:

Мэргэжлийн хяналтын 4-5 байцаагч ⇨ 4704 лиценз

Хуулиудын хоорондын уялдаа холбоог сайжруулах.

- Жишээ нь: “Соёлын өв хамгаалах тухай хууль”, “Гол, мөрний урсац бүрэлдэх эх, усны сан бүхий газрын хамгаалалтын бүс, ойн сан бүхий газарт ашигт малтмал хайх, ашиглахыг хориглох тухай хууль”, “Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хууль” г.м.
- Хууль дүрэм стандартуудыг шинэчлэх, уялдаа холбоог сайжруулах (Жишээ нь байгаль орчны стандарт 1968 оныхоор байна.)

Шийдвэрлэвэл зохих асуудлууд

- Лиценз олгох талбайн хэмжээ жигд бус:
  - Солбилцлын нарийвчлал → нэг тоо зөрөхөд лиценз олгох боломжгүй.
  - Лицензийн талбайн өргөтгөл → боломжгүй буюу зэргэлдээ орших залгаа талбайг авах хүсэлт гаргах нь шинээр лиценз авахтай адил байдаг. Өөрөөр хэлбэл томруулсан нэг талбайд 2 лиценз авна гэсэн үг.
- Ажилчдын хяналт – Ажилтан тухайн байгууллагад үнэхээр ажилладаг эсэхийг шалгаж байх. Ихэнх тохиолдолд 1 геологич хэд хэдэн компанид нэгэн зэрэг ажилдаг гэсэн бүртгэлтэй байна.
- Сонгонд шалгаруултанд оролцож лиценз авах дүрэм журмууд, хэзээ зарлагдах хугацаа зэрэг нь тодорхой бус байдаг.
- Лицензийг нэгтгэж болдог, хуваж болдоггүй.
- Лицензийн төлбөр төлөх хугацааг нэгдсэн журмаар жилд 1 эсвэл 2 удаа болгох

ECONOMIC POLICY AND COMPETITIVENESS RESEARCH CENTER

ЭДИЙН ЗАСГИЙН БОДЛОГО, ӨРСӨЛДӨХ ЧАДВАРЫН СУДАЛГААНЫ ТӨВ

АНХААРАЛ ТАВЬСАНД БАЯРЛАЛАА

WWW.ECRC.MN